



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Рашаант сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БУА-2026/6/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2026 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.03.10 № 202  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т

РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.ЖАВЗМАА ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Рашаант сумын ТТЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рашаант сумын ТТЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Рашаант сумын ТТЗ нь 2025 онд сумын татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг нийт 2,304.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2,287.0 сая төгрөг буюу 99.3 хувиар орлогыг бүрдүүлж ажиллажээ.

Аймгаас төсвөөс 179.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, сумын орон нутгийн төсвөөс 1,912.2, ОНХС-гаас 166.9, нэмэлт дансаар 94.6 сая төгрөгийн буюу нийт 2,347.0 сая төгрөгийн санхүүжилт авч 100 хувийн зарцуулалт хийгджээ.

#### Аудитын гол асуудал

Рашаант сумын ТТЗ-ийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар өмнөх оноос авлага 47.7 сая төгрөгөөр буурч, өглөг 41.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Сангийн яам жилийн эцэст зарим зардлын санхүүжилтийн эрхийг хаасантай холбоотой байна.

Мөн үндсэн хөрөнгө 40.3 сая төгрөгөөр өсч, бараа материал 6.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй тайлагнажээ.

#### **Бусад асуудлын хэсэг**

Шилэн дансанд мэдээлэх 167 мэдээлэлээс 165 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

	/мянган төгрөгөөр/	
Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	453,053.26	443,901.94
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,414,857.45	3,455,151.27
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,867,910.71</b>	<b>3,899,053.21</b>
Нийт өр төлбөрийн дүн	31,558.30	72,792.84
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,836,352.41	3,826,260.37
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,867,910.71</b>	<b>3,899,053.21</b>
<b>Санхүү үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	6,387,349.27	4,513,071.01
Үйл ажиллагааны зардлын дүн	5,355,823.43	4,490,883.81
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>1,031,525.84</b>	<b>22,187.20</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	-	32,279.24
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>1,031,525.84</b>	<b>(10,092.04)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	885,290.05	874,682.38
Тайлант оны үр дүн	1,031,525.84	(10,092.04)
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>2,811,926.57</b>	<b>3,826,260.37</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	5,094,025.80	4,235,809.26
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,390,775.03	3,867,883.66
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>703,250.77</b>	<b>367,925.60</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(709,088.52)</b>	<b>(271,273.70)</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>(130,286.00)</b>	<b>(52,118.90)</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(136,123.75)</b>	<b>44,533.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	285,644.58	149,520.83
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	149,520.83	194,053.82
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>2,304,059.50</b>	<b>4,084,708.03</b>
Урсгал зардал	1,919,698.50	3,846,987.43
Хөрөнгийн зардал	239,361.00	185,601.70
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>3,121,284.80</b>	<b>2,768,373.73</b>
Улсын төсвөөс санхүүжих	3,121,284.80	2,660,218.29
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	108,155.44

**Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Рашаант сумын засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төр засгийн хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, төр иргэдийн хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангаж, нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх таатай орчин бүрдүүлэх, төрийн албаны ил тод байдлыг ханган иргэдэд үйлчлэхэд оршино.” гэж тодорхойлсон байна.

**Дөрөв: Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Рашаант сумын ТТЗ нь 2025 онд сумын татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг нийт 2,304.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2,287.0 сая төгрөг буюу 99.3 хувиар орлогыг бүрдүүлж ажиллажээ.

Аймгаас 179.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, сумын орон нутгийн төсвөөс 1,912.2, ОНХС-гаас 166.9, нэмэлт дансаар 94.6 сая төгрөгийн буюу нийт 2,347.0 сая төгрөгийн санхүүжилт авч 100 хувийн зарцуулалт хийгджээ.

## **Тав. Аудитын гол асуудал**

Рашаант сумын ТТЗ-ийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар өмнөх оноос авлага 47.7 сая төгрөгөөр буурч, өглөг 41.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Сангийн яам жилийн эцэст санхүүжилтийг танасантай холбоотой байна.

Мөн үндсэн хөрөнгө 40.3 сая төгрөгөөр өсч, бараа материал 6.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй тайлагнажээ.

## **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Шилэн дансанд мэдээлэх 167 мэдээлэлээс 165 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

## **Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сумын ОНХС хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байна.

## **Найм. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 13.1 сая төгрөгийн алдаа<sup>1</sup>, зөрчил илэрснээс 5.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 0.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 7.1 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

### **5.1 Төлбөрийн акт**

Тус сум нь Малын татварын тоо, толгойн албан татварын 5.8 сая төгрөгийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;”, Малын тоо, толгойн албан татварын 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүрэг, хотын төсөвт төлнө.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй. гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

#### **5.2.1 Албан шаардлага**

Тус сум нь Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон зээлийг хугацаанд нь төлөөгүй иргэдэд 2025 оны 186,959.00 (нэг зуун наян зургаан мянга, есөн зуун тавин ес) төгрөгийн алдангийг тооцоогүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Багийн бичил зээлийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 1 дүгээр зүйлийн 1.7-д “Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.2 хувийн алданги төлнө.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага бичлээ.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,



Дүн													
-----	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын ЗДТГ	4	2,759.0	3	2,759.0			1	0				
Сумын ТТЗ	3	13,102.0	1	5,826.2	1	186.9	1	7,088.9				
Дүн	7	15,861.0	4	8,585.2	1	186.9	2	7,088.9				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Сумын ОНХС	1	0					1	0
Сумын ТТЗ	1	0					1	0
Дүн	2	0					2	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сумын ЗДТГ								
Дүн								
Нийт дүн	2	0					2	0